

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ахмад настны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.1.7-4.1.11 дахь заалт:**

“4.1.7.“Ахмад настны цогц үнэлгээ” гэж эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, хэрэгцээний болон эрсдлийн зэргийг үнэлэх мэргэжлийн **олон талт** үйл ажиллагааг”;

4.1.8.“Ахмад настны цогц тусламж, үйлчилгээ” гэж энэ хуулийн 4.1.7-д заасан үнэлгээнд суурилан, ахмад настны **хам шинж, асран хамгаалал, нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний** тулгамдсан асуудлыг эрэмбэлэн **хэрэгцээг тогтоож** төлөвлөгөөний дагуу цогцоор үзүүлж, эргэн хянах үйл ажиллагааг”;

4.1.9.“ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ” гэж ахмад настны асруулах эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн өдрөөр, түр, урт хугацаанд байрлуулан асрах, байнга асрах төрөлжсөн асрамжийн, асралт гэр бүлээр асруулах, гэрээр асрах зэрэг бусад шаардлагатай үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан эсхүл хамтран төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцөлөөр үзүүлэх үйл ажиллагааг;

4.1.10.“ахмад настанд үзүүлэх сэргээн засах үйлчилгээ” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.21 дэх заалтад заасан сэргээн засах цогц үйл ажиллагааг ахмад настанд үзүүлэхийг;

4.1.11.“ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлага” гэж ахмад настанд үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг онол, арга зүй, мэргэшлийн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх үйл ажиллагааг.”

#### **2/7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7.1.10-7.1.12 дахь заалт:**

“7.1.10.ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ;

7.1.11.ахмад настны дасгал хөдөлгөөн, эрүүл мэнд, нийгмийн оролцоог дэмжих үйлчилгээ;

7.1.12.ахмад настанд үзүүлэх сэргээн засах үйлчилгээ.”

### **3/7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7.2.9<sup>1</sup>, 7.2.11-7.2.14 дахь заалт:**

“7.2.9<sup>1</sup>.ахмад настанг орчин үеийн шинэ техник хэрэгсэл ашиглах, нийгэм, олон нийтийн хөгжлөөс хоцроохгүй байлгах чиглэлээр соёл урлаг, уран сайхан, гар урлал, хэвлэл нийтлэл, танин мэдэхүй,зэрэг чиглэлээр сургах, сонирхлын клуб, бүлэг ажиллуулан дэмжих.

7.2.11.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан болон өрх, сум, тосгоны эмч нь байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний эрүүл мэнд, ачааллыг үнэлэн, шаардлагатай бол тэднийг түр амраах, асруулагч ахмад настныг түр асрах төв, өдрийн асаргааны төв, сувилахуйн төвд түр байрлуулах, эрүүл мэндийн үйлчилгээ, хөнгөвчлөх эмчилгээнд хамруулах, эсхүл гэр бүлийн бусад гишүүдийн асрамжид шилжүүлэх талаар гэр бүл гишүүдтэй нь зөвшилцөн шийдвэрлэх;

7.2.12.энэ хуулийн 4.1.7, 4.1.8, 4.1.11, 7.1-д заасан заасан үнэлгээ, үйлчилгээ, мэргэжлийн удирдлагын заавар болон энэ хуулийн үйлчилгээ үзүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журмыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлэх;

7.2.13.энэ хуулийн 7.1.6, 7.1.12-т заасан үйлчилгээг эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэл авсан эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан байгууллагаар гүйцэтгүүлэх;

7.2.14. энэ хуулийн 4.1.7-д заасан үнэлгээнд ахмад настан сайн дурын үндсэн дээр орох бөгөөд үнэлгээг хийхдээ ахмад настанд чирэгдэлгүй байхыг анхааран, зарим тохиолдолд цахимаар хийх.”

### **4/7 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“7.8.Төрийн болон орон нутгийн өмчит барилга, байгууламжид байрлаж, энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг үзүүлж байгаа ахмадын өргөө, ахмадын төв, сэргээн засах төв, идэвхтэй насжилтыг дэмжих төв, дасгалын клуб, олон нийтийн төвийн **барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг** орон нутгийн төсвөөс гэрээний үндсэн дээр хэсэгчлэн болон бүрэн санхүүжүүлнэ.”

### **5/9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9.1.4-9.1.7 дахь заалт:**

“9.1.4.хөдөлмөрийн, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран ахмад настан боловсролын байгууллагад ажиллах, насан туршийн боловсрол олгох чиглэлээр ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.5. хөдөлмөрийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран сэргээн засалтын, идэвхтэй насжилтыг дэмжих болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагад ахмад настныг ажиллахыг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.6.хөдөлмөрийн, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, байгаль **орчин, аялал жуулчлалын зэрэг** асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран үйлдвэржилтийг эрчимжүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад чиглэлээр УИХ-аас баталсан үндэсний хэмжээний бодлого, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ахмад настан хувиараа хөдөлмөр, өрхийн аж ахуй эрхлэхийг техник, технологи, хөрөнгө санхүүгээр дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.7.энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг ахмад настан, ахмадын байгууллага, ахмад настны **холбоо, сан, хоршоо**, ахмадын оролцоотой байгууллага гэрээлэн гүйцэтгэхийг дэмжиж, энэ чиглэлээр хувиараа ажилласан ахмад настны цалин хөлсийг ажилласан цагаар, өдрөөр, сараар тооцон гэрээний дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон хууль тогтоомжийн дагуу бусад холбогдох сангаас санхүүжүүлэх.”

#### **6/9 дүгээр зүйлийн 9.9-9.13 дахь хэсэг:**

“9.9.Ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч өөрөө хүсвэл ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тэтгэврийн даатгалд төлөх шимтгэл 8.5 хувийг Нийгмийн даатгалын санд төлөхгүй.

9.10.Төрийн албаны тухай хуулийн 27.4-т заасан нөхцөл үүссэн бол төрийн жинхэнэ албанд ажиллаж байсан, Ахмад настны тухай хуулийн 3.1, 3.2 дахь хэсэгт заасан иргэнийг мэргэжил, ур чадварыг нь харгалзан томилон ажиллуулж болно.

9.11.Аж ахуйн нэгж, байгууллага нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1–д заасан насанд хүрсэн ахмад настныг өөрөө хүсэлт гаргаагүй байхад нь тэтгэвэрт гарахыг шаардах, энэ үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн гэрээ цуцлахыг хориглоно.

9.12.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа хоёр хувиас доошгүй орон тоонд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлтэй болон газрын доорх ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна.”

#### **7/ 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт:**

“11.1.4.Ахмад настны талаарх иргэд, байгууллага, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах, ахмад настны хуримтлуулсан мэдлэг, туршлагыг залуу үедээ өвлүүлэх, тэднийг сонсох, ахмад настныг нийгэм, олон нийтийн дунд сайн сайхан ажиллаж, амьдрах нөхцөлийг дэмжих зорилгоор ахмадын өдрийг жил бүрийн 10 дугаар сарын 01, ахмадын долоо хоногийг 10 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд тэмдэглэнэ. Бүх шатны Засаг дарга нар, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн бус байгууллагууд энэ өдрүүдэд дээрх зорилгод нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.”

## **8/ 13 дугаар зүйлийн 13.5-13.11 дэх хэсэг:**

“13.5.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ, 8.1.1, 8.1.2, 10.1.2-т заасан дэмжлэгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сан, нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс болон ахмад настны оролцоотойгоор санхүүжүүлнэ.

13.6.Энэ хуулийн 13.5-д заасан үйлчилгээний жишиг үнэ, төлбөр, хөнгөлөлтийн хэмжээ, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, нийгмийн халамжийн болон орон нутгийн төсвөөс хариуцах санхүүжилт болон иргэний хариуцах төлбөрийг нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлнэ.

13.7.Энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нь нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зориулан зарцуулах нийт хөрөнгөний 10 хувиас багагүй байна.

13.8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад настанд зарцуулах хөрөнгө нь эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн зардлыг оруулахгүйгээр тус сангийн тухайн жилийн нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна.

13.9.Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-9.1.6-д заасан арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон боловсролын, эрүүл мэндийн, хөдөлмөрийн, байгаль орчны, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

13.10. Энэ хуулийн 8.1.2, 10.1.2-т заасан амралт, сувиллын үйлчилгээний хөнгөлөлт, зардлыг ижил хугацаанд нэг байгууллагад нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн даатгалын сангаас давхардуулан олгохгүй.

13.11.Энэ хуулийн 7.1, 8.1.1, 8.1.2, 10.1.2 болон 10.2-т заасан үйлчилгээг үзүүлэхдээ үйлчилгээг цахимжуулах, үйлчилгээний давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитоор олгох зорилгоор ахмад настны биометрик мэдээллийг ашиглаж болно.”

## **9/ 14 дүгээр зүйлийн 14.9-14.11 дэх хэсэг:**

“14.9.Аж ахуйн нэгж, байгууллага нь ахмадын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын талаар жил бүрийн 2 дугаар сарын 01-ний дотор харьяалагдах дээд байгууллагадаа тайлагнаж, хамт олондоо мэдээлнэ.

14.10.Ахмад настны нийгмийн болон хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, үл хайхрах, хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, таслан зогсоох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хууль зүйн, хөдөлмөрийн, халамжийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтын нэгжүүд холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

14.11. Их, дээд сургуульд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, сувилагчийн мэргэжлээр суралцаж буй оюутны ахмад настны асаргааны хувилбарт

үйлчилгээний байгууллагад хийсэн сайн дурын ажлыг сургалтын хөтөлбөрийн дагуу хийх дадлагын ажлын цагт тооцож болно. Дадлагын цагт тооцох журмыг ахмад настны болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

#### **10/ 15 дугаар зүйлийн 15.3-15.9 дэх хэсэг:**

“15.3.Ахмад настны талаарх төрийн болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг болон энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг Ахмадын байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг гэрээний үндсэн дээр хэсэгчлэн болон бүрэн санхүүжүүлж болно.

15.4.Ахмадын байгууллага нь энэ хуулийн 15.2-т заасан санхүүжилтийг авч энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ, ахмад настны талаарх төрийн болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг гүйцэтгэхдээ тухайн үйлчилгээний чиглэлээс хамааран нийгмийн халамжийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, аймаг, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж, үр дүн, санхүүжилтийн тайланг гэрээнд заасны дагуу тухай бүр тайлагнана.

15.5.Ахмадын байгууллага нь төрөөс ахмад настны талаар баримтлах бодлого, хууль тогтоомжид санал өгөх, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, оролцох, хяналт тавих, хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх, ахмадын мэдээллийн санг бүрдүүлэн, баяжуулж, дүгнэлт гаргана.

15.6. Ахмадын байгууллага нь Ахмад настны асрамж сувилал, үйлчилгээний байгууллагуудыг магадлан итгэмжлэх зөвлөл, хүний эрхийн иргэний зөвлөл, амьжиргаа дэмжих зөвлөл, хохирогчдын нөхцөл, аюулгүй байдлын үнэлгээ, зэрэглэл тогтоох ажлын хэсэг, зөвлөлүүдэд төлөөллөө оролцуулна.

15.7.Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий төсөл, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ зэрэгт зориулагдах төсвийн санхүүжилтийг ахмадын байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

15.8.Энэ хуулийн 15.2, 15.4, 15.7-д заасан гэрээ, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн тайлан нь олон нийтэд ил тод, нээлттэй байна.

15.9.50 ба түүнээс дээш ахмад настантай төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагын ахмадын зөвлөл тогтмол үйл ажиллагаатай, тухайн байгууллагыг ахмадуудтайгаа харилцах үндсэн чиг үүрэгт зөвлөх, туслах үүрэгтэй байх бөгөөд ахмад зөвлөлийн нэг ажилтныг орон тоондоо багтаан цалинжуулна.“

#### **11/ 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг:**

“16.3.Энэ хуулийн 14.7-д заасан ахмадын сангийн хуримтлал үүсгээгүй тохиолдолд төсөв захирагчид байгуулбал зохих ахмадын сангийн дүнгийн 0.3 хувиар торгууль ногдуулж Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцно.”

**2 дугаар зүйл.** Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.1.6 дахь заалтын “гэм хор” гэсний өмнө “болон ахмад настны өмчлөлийн байр, орон

сууц, газар, бусад эд хөрөнгө, тэтгэвэр, мөнгөн хөрөнгийг нь түүний зөвшөөрөлгүйгээр болон айлган сүрдүүлэх, дарамт, шахалт үзүүлэн хүч хэрэглэн авч ашиглах зэргээр” гэж, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7.2.5 дахь заалтын “үйл ажиллагааг” гэсний өмнө “болон ахмад настны сайн дурын” гэж, “7.2.6” гэсний өмнө “7.1.6, 7.1.12,” гэж, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7.2.10 дахь заалтын “нийгмийн ажилтан” гэсний дараа “болон сум, тосгон, өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн” гэж, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8.1.3 дахь заалтын “олгох” гэсний өмнө “эсхүл түлш худалдан авах эрхийн бичиг” гэж, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8.1.5 дахь заалтын “үнэ төлбөргүй” гэсний дараа “/нийслэлд зориулалтын хөнгөлөлтийн картаар/” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.2 дахь заалтын “бичгийн” гэсний дараа “жишиг” гэж, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “санхүүжүүлэн” гэсний дараа “ахмад настны наснаас хамааран” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “цалингийн” гэсний өмнө “төсөвт байгууллага тухайн жилийн төсвийн зардалдаа тусган” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Ахмад настны тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь хэсэг:**

“7.1.7. ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ;”

**2/ 7 дугаар зүйлийн 7.3, 7.6 дахь хэсэг:**

“7.3. Энэ хуулийн 7.2.13-т зааснаас бусад энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.”

“7.6. Энэ хуулийн 7.1-д заасан зарим төрлийн үйлчилгээг аймаг, дүүрэг, сум, тосгон, хороонд үйл ажиллагаа явуулж байгаа ахмадын өргөө, ахмадын төв, сэргээн засах төв, идэвхтэй насжилтыг дэмжих төв, дасгалын клуб, бусад олон нийтийн төвүүд үйлчилгээ үзүүлж байна.”

**3/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8.1.1 болон 8.1.6 дахь заалт:**

“8.1.1. хөл, гар, шүдний протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр, нэн шаардлагатай тусгай хэрэгсэл худалдан авсан зардлын үнийн хөнгөлөлтийг гурван жилд нэг удаа эрүүл мэндийн даатгалын сангаас олгох;”

“8.1.6. энэ хуулийн 8.1.5-т заасан үнэ төлбөргүй зорчих төлбөрийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх.”

**4/ 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг:**

“15.1. Ахмадын байгууллагын бүтэц нь ахмад настны олонхын нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж нийгэмд үйлчилдэг, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг өөрөө удирдах ёсны зарчимтай, бүх төрлийн

татвараас чөлөөлөгдсөн, төрийн бус байгууллага (Монголын ахмадын холбоо), аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, аж ахуйн нэгж байгууллагын ахмадын хороо зөвлөл (цаашид “Ахмадын байгууллага” гэх)-өөс бүрдэнэ.”

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан ахмадын байгууллагын үндсэн ажилтны цалин, тогтмол болон үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс, орон нутгийн ахмадын байгууллагын зардлыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс, аж ахуйн нэгж, байгууллагын ахмадын хороо, зөвлөлийн зардлыг тухайн байгууллагын төсөв, орлогоос тус тус санхүүжүүлнэ.”

**4 дүгээр зүйл.** Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8.1.3-т заасан “тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон” гэснийг, “Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-т заасан өрхийн” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “7” гэснийг “6” гэж, “олгох” гэсний өмнөх “хишиг” гэснийг “хишгийн хэмжээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “үйлчилгээ, дэмжлэг хүндэтгэлийн хэмжээ” гэснийг “дэмжлэгийн хэмжээ” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

**5 дугаар зүйл.** Ахмад настны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10.1.2 дахь заалтын “рашаан” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “7.1-д заасан үйлчилгээ” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг хүчингүй болгосонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг дор дурдсанаар нэмсүгэй:

“145.4. Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа хоёр хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлтэй, газрын доорх ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд дор дурдсан заалт нэмсүгэй:

1/ 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 23.1.5 дахь заалт:

“23.1.15. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих.”

**2 дугаар зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 22.1.7 дахь заалтын “хөгжлийн” гэсний өмнө “Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүн,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуульд доор дурдсан хэсэг, заалт нэмсүгэй.

1/19 дүгээр зүйлийн 19.11-19.15 дахь хэсэг:

“19.11.Энэ хуулийн 19.1.1-т заасан үйлчилгээг шинээр үзүүлэх, барилга байгууламж барих хувийн хэвшил, төрийн бус байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлж болно.

19.12.Энэ хуулийн 19.11-т заасан дэмжлэгийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

19.13.Энэ хуулийн 19.5.1-д заасан нэг хүнд ногдох зардлын нормативыг байнгын асаргаа шаардлагатай иргэнд 3 дахин нэмэгдүүлэн тооцно.

19.14.Энэ хуулийн 19.11-т заасны дагуу ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулж байгаа хувийн хэвшил, төрийн бус байгууллагад энэ хуулийн 19.5-д заасан нормативын дагуу асруулагчийн тоогоор зардлыг тооцох бөгөөд, тухайн асрамжийн байгууллагын ажилтнуудын цалин, урсгал зардал зэрэг үйл ажиллагааны зардалд үзүүлэх дэмжлэгийн хэмжээг нийгмийн халамжийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно.

19.15. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн **15.1.16-д** заасан зардал, дэмжлэг, хандивыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцуулж болно.”

**2 дугаар зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

“18.7.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам, үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар болон үйлчилгээний үнэ тариф, аргачлал, зааврыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн гишүүн батална.”

**3 дугаар зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан “нийгмийн хамгааллын” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8, 18.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд дараах заалт нэмсүгэй:

#### **1/15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“15.1.16.нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг бүх шатны нийгмийн халамжийн байгууллагатай гэрээлэн гүйцэтгэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллах хүчний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээс бусад үйл ажиллагааны зардал;

15.1.17. асрамж халамжийн байгууллага шинээр байгуулах барилга байшин барих, түүнд зориулсан тоног, төхөөрөмж, материал.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд дараах хэсэг нэмсүгэй:

“27.4. Төрийн жинхэнэ албан тушаалын сонгон шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд мэргэжил, ур чадварыг нь харгалзан төрийн жинхэнэ албанд ажиллаж байсан, Ахмад настны тухай хуулийн 3.1, 3.2 дахь хэсэгт тус тус заасан иргэнийг томилон ажиллуулж болно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Компанийн тухай хуульд дараах заалт нэмсүгэй:

**1/16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 16.2.8 дахь заалт:**

“16.2.8.Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсэгт заасны дагуу үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулан ажиллуулах үйл ажиллагааны талаар.”

**2/ 76 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 76.1.19 дэх заалт:**

“76.1.19.Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсэгт заасны дагуу "Ахмадын сан" байгуулан ажиллах журмыг батлах.“

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай дараах заалтууд нэмсүгэй.

**1/19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 16, 17 дахь заалт:**

“9.1.16.Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-т заасан үйлчилгээ;

9.1.17.Ахмад настны тухай хуулийн 8 дугаар 8.1.1 дэх заалтад заасан хөнгөлөлт, үйлчилгээ.”

**2/11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1<sup>1</sup> дэх заалт:**

“11.1.1<sup>1</sup>.Энэ хуулийн 9.1.17-д заасан хөнгөлөлт, үйлчилгээний зардлыг улсын төсвөөс хариуцах бөгөөд жил бүр эрүүл мэндийн даатгалын төсөвт тусгана.

**3/19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3<sup>1</sup> дэх заалт:**

19.1.3<sup>1</sup>.Энэ хуулийн 9.1.17-д заасан хөнгөлөлт, үйлчилгээний зардалд улсын төсвөөс олгосон санхүүжилт.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

#### **1/16 дугаар зүйлийн 1<sup>1</sup> дэх хэсэг:**

“16.1<sup>1</sup>.Энэ хуулийн 15.1.7, 15.1.11-15.1.13-д заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын дэргэд иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цаг богиносгох, хөгжлийн бэрхшээлтэйг тогтоох саналаа Эмнэлэг магадлалын комисст тавих, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байнгын асаргаа шаардлагатайг тодорхойлох, эмнэлгийн магадалгаа олгох, хугацааг нь сунгах, гадаад улс, дотоодын эмнэлэгт өвчтөн илгээх, шилжүүлэх талаар дүгнэлт гаргах, иргэнд протез, ортопед хийлгэх шаардлагатайг тогтоох асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий Эмнэлэг хяналтын комисс ажиллуулна.”

#### **2/16 дугаар зүйлийн 1<sup>2</sup> дэх хэсэг:**

“16.1<sup>2</sup>.Эмнэлэг хяналтын комиссын дүрэм, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 1.2<sup>1</sup> дэх заалт нэмсүгэй:

“1.2<sup>1</sup>.Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт зааснаас бусад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн хөрөнгийг түүний зөвшөөрөлгүйгээр айлган сүрдүүлэх, дарамт, шахалт үзүүлэн хүч хэрэглэх замаар ашиглах;”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.3<sup>1</sup> дэх заалт нэмсүгэй:

“4.3<sup>1</sup>.Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт зааснаас бусад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн хөрөнгийг түүний зөвшөөрөлгүйгээр айлган сүрдүүлэх, дарамт, шахалт үзүүлэн хүч хэрэглэх замаар ашиглах;”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 35.2.3 дахь заалтын “зөвшөөрөлтэй” гэсний өмнө “оршуулгын үйл ажиллагааны жишиг үнэ” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 35.2.6, 35.2.7 дахь хэсэг:

“35.2.6.ганц бие орон гэргүй тэнэмэл амьдралтай, эсхүл түр байрлуулах, түр хоноглох зэрэг газар байрлаж байсан ганц бие иргэн нас барсан, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бөгөөд түүний гэр бүл, төрөл, садан хүсэлт гаргасан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журам;

35.2.7.ганц бие иргэн нас барсан, эсхүл хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвлөгдвөл зохих эд хөрөнгө эзэнгүй эд хөрөнгийн нэг адил төрийн өмчлөлд шилжсэн бол, мөн бусад шалтгаанаар хууль тогтоомжийн дагуу төрийн өмчлөлд шилжсэн эд хөрөнгийг улсын хөрөнгөд бүртгэх, захиран зарцуулах журам.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ